## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

## ДӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын код: ХОА**-2021/159**/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Ховд хот<br>2021 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нарантуул<br>Утас: 70432545<br>цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn |

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| БСШУСЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яам |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| БҮТЭЗ | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....11
3. Аудитын тайлан ....11
3.1. Ерөнхий зүйл ....11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....12
3.4. Материаллаг байдал ....12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....15
3.7. Шилэн дансны мэдээлэл....16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16
3.9. Аудитын илрүүлэлт....17
Залруулсан алдаа ....17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....
Аудитын зөвлөмж ....17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....18
4. Менежментийн захидал ....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....18

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021-02-25 № 2/98
танай ________ -ны № ________ -т

ДӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.БАТТОГТОХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөргөн сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дөргөн сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, төрийн үйлчилгээг нутаг дэвсгэртээ хуулийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Аудитын гол асуудал**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагааны хуулийн заалтуудыг мөрдөөгүй, ажил хавсран гүйцэтгүүлэхдээ Төрийн албаны хуулийн заалтыг зөрчсөн, орлого дутуу тусгасан, тайлант оны үр дүн зөрүүтэй илэрхийлсэн, Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ТБНӨХБАУХА-ны тухай хуулийн заалтуудыг мөрдөөгүй, аудитын "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын

021020351

стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 57,179,910 | 27,480,981.59 |
| **33** | **АВЛАГА** | 9,084,230 | 4,238,401.59 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,250,500 | 1,910,598.59 |
| **335** | **Бусад авлага** | 7,833,730 | 2,327,803 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 7,833,730 | 2,327,803 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 31,416,000 | 600,000 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 31,416,000 | 600,000 |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 30,816,000 | |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 600,000 | 600,000 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 16,679,680 | 22,642,580 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,327,300 | 1,547,300 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,327,300 | 1,547,300 |
| **354** | **Хангамжийн материал** | 15,052,300 | 20,795,200 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,712,000 | 2,920,800 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,340,300 | 17,624,400 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 250,000 |
| 35600 | Мал амьтад | 300,080 | 300,080 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,011,138,539.14 | 1,109,606,945.52 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,011,138,539.14 | 1,109,606,945.52 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 975,989,339.14 | 1,074,719,495.52 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 552,982,164.26 | 691,542,072.26 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (74,131,808.44) | (164,107,716.53) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 263,695,000 | 263,695,000 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (145,672,383.89) | (182,917,383.77) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 101,717,780 | 148,965,923 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (78,684,538.19) | (99,219,223.80) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 54,478,519 | 56,378,519 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (29,359,553.25) | (33,214,410.01) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 53,578,350 | 53,578,350 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (6,697,293.72) | (13,394,587.44) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 800,000 | 800,000 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 455,075,766 | 592,733,637 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (206,162,662.63) | (274,490,684.19) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 34,370,000 | 34,370,000 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 35,149,200 | 34,887,450 |
| 39301 | Програм хангамж | 2,302,000 | 2,302,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,095,000) | (1,356,750) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 33,942,200 | 33,942,200 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,068,318,449.14** | **1,137,087,927.11** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **315,111.35** | **78,700.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 315,111.35 | 78,700 |
| **413** | **Өглөг** | 315,111.35 | 78,700 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 236,411.35 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 78,700 | 78,700 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 41,500 | 41,500 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 37,200 | 37,200 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,068,003,337.79** | **1,137,009,227.11** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,068,003,337.79 | 1,137,009,227.11 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 792,963,994 | 792,963,994 |
| 51101 | Өмч: - төрийн | 792,963,994 | 792,963,994 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 93,195,810.15 | 162,201,699.47 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 93,195,810.15 | 93,409,467.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 68,792,232.05 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 181,843,533.64 | 181,843,533.64 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,068,318,449.14** | **1,137,087,927.11** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | **562,894,254** | **691,631,120** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | **150,792,006** | **285,500,922** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 150,792,006 | 285,500,922 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 150,792,006 | 285,500,922 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 605,000 | 605,000 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 150,187,006 | 284,895,922 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | **412,102,248** | **406,130,198** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 108,383,348 | 51,263,098 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 42,858,442 | 3,116,500 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 64,182,906 | 48,146,598 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,342,000 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 303,718,900 | 354,867,100 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 296,493,400 | 345,637,100 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 7,225,500 | 9,230,000 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | **500,089,208.22** | **622,838,887.95** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | **500,089,208.22** | **622,838,887.95** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 500,034,208.22 | 618,931,471.95 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 187,376,009 | 218,144,840 |
| 210101 | Үндсэн цалин | 162,009,576 | 216,844,840 |
| 210102 | Нэмэгдэл | 22,642,395 | 400,000 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,724,038 | 900,000 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,315,122.35 | 26,546,583.33 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,192,578.48 | 17,838,837.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,787,362.17 | 2,175,336.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,429,889.73 | 1,743,149.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 355,026.55 | 435,387.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,550,265.42 | 4,353,872.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,264,650 | 27,839,300 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,948,300 | 4,139,900 |
| 210302 | Түлш, халаалт | 14,316,350 | 23,699,400 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,112,022 | 30,780,373 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,604,600 | 4,331,500 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,488,922 | 22,489,373 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,018,500 | 3,959,500 |
| **2105** | **Нормативт зардал** | 161,900 | 209,000 |
| 210502 | Хоол, хүнс | - | 29,000 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 161,900 | 180,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,655,200 | - |
| 210604 | Урсгал засвар | 11,655,200 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,233,600 | 908,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,233,600 | 908,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,308,958 | 22,530,030 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,641,978 | 21,810,830 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100,000 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 224,700 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 363,800 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19,180 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 46,000 | 494,500 |
| 210807 | Газрын төлбөр | 138,000 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 202,606,746.87 | 291,973,345.62 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,353,118 | 65,075,830 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 143,253,628.87 | 226,897,515.62 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 55,000 | 3,907,416 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 55,000 | 200,000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 55,000 | 200,000 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 3,707,416 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,707,416 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | 62,805,045.78 | 68,792,232.05 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 62,805,045.78 | 68,792,232.05 |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **412,707,248** | **414,568,928** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **605,000** | **8,438,730** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 605,000 | 8,438,730 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 605,000 | 605,000 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 605,000 | 605,000 |
| 120009 | Бусад орлого | - | 7,833,730 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **412,102,248** | **406,130,198** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 108,383,348 | 51,263,098 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 42,858,442 | 3,116,500 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 64,182,906 | 48,146,598 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 303,718,900 | 354,867,100 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 296,493,400 | 345,637,100 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 7,225,500 | 9,230,000 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **412,707,248** | **414,568,928** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **412,707,248** | **414,568,928** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **404,653,518** | **410,441,512** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 186,800,000 | 218,298,900 |
| 210101 | Үндсэн цалин | 132,114,333 | 145,946,748 |
| 210102 | Нэмэгдэл | 21,886,660 | 44,470,670 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 32,799,007 | 27,881,482 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,387,400 | 29,870,700 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,917,800 | 20,875,400 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,871,000 | 2,186,800 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,496,800 | 1,749,400 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 359,800 | 437,400 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,742,000 | 4,621,700 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,845,900 | 30,347,200 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,321,700 | 5,226,900 |
| 210302 | Түлш, халаалт | 14,524,200 | 25,120,300 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,566,900 | 20,449,461 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,297,100 | 2,851,100 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,391,500 | 14,180,600 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,878,300 | 3,417,761 |
| **2105** | **Нормативт зардал** | 402,000 | 363,600 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 402,000 | 363,600 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,059,400 | 3,037,200 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000 | 100,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 3,859,400 | 2,937,200 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,242,722 | 1,829,500 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,242,722 | 1,829,500 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,653,769 | 16,408,030 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,878,769 | 15,543,030 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100,000 | 160,000 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 100,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 260,000 | 15,100 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000 | 17,900 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 247,000 | 425,000 |
| 210807 | Газрын төлбөр | 138,000 | 147,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 124,695,427 | 89,836,921 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 124,695,427 | 89,836,921 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,053,730** | **4,127,416** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 220,000 | 420,000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 220,000 | 420,000 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7,833,730 | 3,707,416 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,833,730 | 3,707,416 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 792,963,994 | 181,843,533.64 | 93,195,810.15 | 1,068,003,337.79 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **792,963,994** | **181,843,533.64** | **93,195,810.15** | 1,068,003,337.79 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **792,963,994** | **181,843,533.64** | **93,195,810.15** | 1,068,003,337.79 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **792,963,994** | **181,843,533.64** | **93,195,810.15** | 1,068,003,337.79 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 213,657.27 | 213,657.27 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **792,963,994** | **181,843,533.64** | **93,409,467.42** | 1,068,216,995.06 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 68,792,232.05 | 68,792,232.05 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **792,963,994** | **181,843,533.64** | **162,201,699.47** | 1,137,009,227.11 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

| | Үзүүлэлт | Өмнөх оны | Тайлант оны |
|---|---|---|---|

| Эдийн засгийн ангилал | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 304,323,900 | 304,323,900 | 355,378,300 | 354,092,487 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 304,323,900 | 304,323,900 | 355,378,300 | 354,092,487 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 304,103,900 | 304,103,900 | 355,158,300 | 353,672,487 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 187,099,100 | 186,800,000 | 218,677,200 | 218,298,900 |
| 210101 | Үндсэн цалин | 131,540,900 | 132,114,333 | 151,594,100 | 145,946,748 |
| 210102 | Нэмэгдэл | 25,710,100 | 21,886,660 | 36,652,500 | 44,470,670 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 29,848,100 | 32,799,007 | 30,430,600 | 27,881,482 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,387,400 | 23,387,400 | 29,521,500 | 29,870,700 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,903,400 | 15,917,800 | 20,774,400 | 20,875,400 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,871,000 | 1,871,000 | 2,186,800 | 2,186,800 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,496,800 | 1,496,800 | 1,749,400 | 1,749,400 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 374,200 | 359,800 | 437,400 | 437,400 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,742,000 | 3,742,000 | 4,373,500 | 4,621,700 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,702,900 | 19,845,900 | 29,703,900 | 30,347,200 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,883,700 | 5,321,700 | 5,289,700 | 5,226,900 |
| 210302 | Түлш, халаалт | 14,819,200 | 14,524,200 | 24,414,200 | 25,120,300 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 19,126,100 | 18,566,900 | 20,743,700 | 20,449,461 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,148,100 | 3,297,100 | 3,148,100 | 2,851,100 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,563,000 | 12,391,500 | 14,180,600 | 14,180,600 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,415,000 | 2,878,300 | 3,415,000 | 3,417,761 |
| 2105 | **Нормативт зардал** | 402,000 | 402,000 | 402,000 | 363,600 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 402,000 | 402,000 | 402,000 | 363,600 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,537,200 | 4,059,400 | 3,837,200 | 3,037,200 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000 | 200,000 | 200,000 | 100,000 |
| 210604 | Урсгал засвар | 3,337,200 | 3,859,400 | 3,637,200 | 2,937,200 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 7,812,300 | 7,242,722 | 1,812,300 | 1,829,500 |
| 210701 | Гадаад албан томилолт | | | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,812,300 | 7,242,722 | 1,812,300 | 1,829,500 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 32,677,900 | 19,653,769 | 14,577,000 | 13,722,400 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,742,900 | 18,878,769 | 13,455,000 | 12,857,400 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 260,000 | 100,000 | 260,000 | 160,000 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | | - | 100,000 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 260,000 | 260,000 | 260,000 | 15,100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 30,000 | 30,000 | 30,000 | 17,900 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 247,000 | 247,000 | 425,000 | 425,000 |
| 210807 | Газрын төлбөр | 138,000 | 138,000 | 147,000 | 147,000 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,359,000 | 24,145,809 | 35,883,500 | 35,753,526 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,359,000 | 24,145,809 | 35,883,500 | 35,753,526 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 220,000 | 220,000 | 220,000 | 420,000 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 220,000 | 220,000 | 220,000 | 420,000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 220,000 | 220,000 | 220,000 | 420,000 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 304,323,900 | 304,323,900 | 355,378,300 | 354,092,487 |
| 1320 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 303,718,900 | 303,718,900 | 354,773,300 | 353,487,487 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 276,201,000 | 276,201,000 | 345,543,300 | 344,257,487 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 27,517,900 | 27,517,900 | 9,230,000 | 9,230,000 |
| 120004 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 605,000 | 605,000 | 605,000 | 605,000 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 605,000 | 605,000 | 605,000 | 605,000 |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **100,549,618** | **56,769,025** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **100,549,618** | **56,769,025** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 100,549,618 | 56,769,025 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 2,685,630 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 2,685,630 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 100,549,618 | 54,083,395 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 100,549,618 | 54,083,395 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 100,549,618 | 56,769,025 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 100,549,618 | 56,769,025 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 42,858,442 | 3,116,500 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 56,349,176 | 53,652,525 |

## 3.АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Дөргөн сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тамгын газрын дарга Б.Баттогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дөргөн сумын ЗДТГазар нь сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг нийгмийн тухай жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд Тамгын газрын үйл ажиллагааг чиглүүлж Засаг даргын бодлого төлөвлөлт, хяналт зохицуулалтын шаардлагатай зөвлөгөө үйлчилгээг цаг тухайд нь үзүүлэх замаар Засаг даргаас үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Тухайн шатны хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’*

## 3.3 **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО**, **ДОТООД ХЯНАЛТ**

Дөргөн сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Мөн сумын ЗДТГазар болон Санхүүгийн албанаас дотоод аудитын нэгжгүй, хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан ирүүлээгүй болно.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2020 онд хийгдсэн хяналт хийгдээгүй, аймгийн Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

## 3.4. **МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 562894.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 5628.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 741631.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7416.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

## 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дөргөн сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 116686.2 мянган төгрөгөөр буюу 11 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Авлага | 40,500.2 | 4,838.4 | (35,661.8) |
| Бараа материал | 16,679.7 | 22,642.6 | 5,962.9 |
| Үндсэн хөрөнгө | 1,011,138.5 | 1,109,606.9 | 98,468.4 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | 1,068,318.4 | 1,137,087.9 | 68,769.5 |
| **Богино хугацаат өр төлбөр** | 315.1 | 78.7 | (236.4) |
| Цэвэр хөрөнгө, өмч | 1,068,003.3 | 1,137,009.2 | 69,005.9 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 1,068,318.4 | 1,137,087.9 | 68,769.5 |

Авлага дансны үлдэгдэл 4838.4 мянган төгрөг болж 35661.6 мянган төгрөгөөр буурсан шалтгаан нь сумын өмнөх оны хөрөнгө бэлтгэхтэй холбоотой авлагыг барагдуулсан холбоотой үүссэн бөгөөд үлдэгдэл энэ авлага бүрэн барагдах боломжтой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 22642.6 мянган төгрөг болж 5962.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр БҮТЭЗ-ийг бэлтгэсэнтэй холбоотой өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 300.1 мянган төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байгаа ч 2018 оны өвлийн зудаар хорогдсон боловч тухайн үед малын эмчийн тодорхойлолт дүгнэлт гаргуулаагүй бодитоор оршин байхгүй байна.

| № | Үзүүлэлт | Дүн |
|---|---|---|
| 1 | **Оны эхний үлдэгдэл** | 16,679.7 |
| 2 | Нэмэгдсэн | 56,983.2 |
| 2.1 | Худалдан авсан | 56,733.2 |
| 2.2 | Хандиваар | 250.0 |
| 3 | Хасагдсан | 51,020.3 |
| 3.1 | Худалдсан, зарцуулсан | 51,020.3 |
| 4 | **Эцсийн үлдэгдэл** | 22,642.6 |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1552941.8 мянган төгрөг, оны эцэст 1878307.7 мянган төгрөгөөр болж 325365.9 мянган төгрөгөөр өссөн байна .

Үндсэн хөрөнгийн данс нь 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 138559.9 мянган төгрөгөөр халуун усны барилга, гар болон сагсан, хөл бөмбөгийн талбай, тайз, усан оргилуур 97849.9, Хөшөөт хөгжлийн сангийн хөрөнгөөр давсны үйлдвэрийн тоног төхөөрөмж 38520.0, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 46379.0, төсвийн хөрөнгөөр 2200.0, аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтсээс 1857.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2019 онд УТХО-оор хандиваар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авч хөрөнгө нэмэгдсэн байна.

| № | Үзүүлэлт | Дүн |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| 1 | **Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | 1,552,941.8 |
| 2 | Нэмэгдсэн | 325,365.9 |
| 2.1 | Худалдан авсан | 2,200.0 |
| 2.2 | Хандиваар | 323,165.9 |
| 3 | Хасагдсан | - |
| 3.1 | Акталсан | |
| 4 | **Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,878,307.7 |
| 6 | Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл | 541,803.2 |
| 801 | Элэгдлийн зардал тайлант хугацааны | 226,897.5 |
| | Дансны хасалт | |
| 10 | Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл | 768,700.7 |
| 11 | **Үлдэгдэл өртөг** | 1,109,607.0 |

Өр төлбөр оны эхэнд 315.1 мянган төгрөг оны эцэст үлдэгдэл 78.7 мянган төгрөг болж 236.4 мянган төгрөгөөр буурсан, барагдуулах боломжтой үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1184925.9 мянган төгрөг болж өмнөх оноос 116922.6 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд ашигтай ажилласантай холбоотой байна.

Дөргөн сумын ЗДТГазрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 128736.9 мянган төгрөгөөр буюу 22.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 128737.2 мянган төгрөгийн орлогоос 49144.0 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 2004.5 мянган төгрөгөөр орон нутгаас авах санхүүжилт, 134708.9 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэн, 57120.2 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлого буурсантай холбоотой байна.

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 562,893.9 | 691,631.1 | 128,737.2 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 605.0 | 605.0 | - |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 150,187.0 | 284,895.9 | 134,708.9 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 296,493.1 | 345,637.1 | 49,144.0 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 108,383.3 | 51,263.1 | (57,120.2) |
| Орон нутгаас санхүүжих | 7,225.5 | 9,230.0 | 2,004.5 |

Нийт зардал өмнөх оноос 124605.6 мянган төгрөгөөр буюу 24.6 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд тус тус өссөн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, эд хогшил, урсгал засварын зардал, томилолтын зардлууд буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн холбоотой байна.

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| **2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | 500,084.2 | 624,689.8 | 124,605.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 187,376.0 | 218,114.8 | 30,738.8 |
| 2102 | Ажил олгогчоос даатгалд төлөх | 22,315.1 | 26,546.6 | 4,231.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,264.7 | 27,839.3 | 8,574.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 22,112.0 | 30,780.4 | 8,668.4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 161.9 | 2,090.0 | 1,928.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,655.2 | | (11,655.2) |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,233.6 | 908.0 | (4,325.6) |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 29,304.0 | 22,530.0 | (6,774.0) |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 202,606.7 | 291,973.3 | 89,366.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 55.0 | 3,907.4 | 3,852.4 |

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 213.7 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга хийсэн тайлант оны үр дүн 68792.2 мянган төгрөгийн ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

## 3.6. **Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 319460.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 319460.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 355378.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 345543.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 9230.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 605.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 345637.1 мянган төгрөг, ОНХС-аас 9230.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 605.0 мянган төгрөг, нийт 355472.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 354092.5 мянган төгрөгийг зарцуулж 1397.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн, 93.8 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг илүү олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 354092.5 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 408.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 786.4 мянган төгрөгөөр, дотоод томилолтын зардлыг 800.4 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 5.0 мянган төгрөг, нормативд зардлыг 20.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээ 1285.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт 3 Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт /мян.төг/

| код | хөтөлбөр, арга хэмжээ | мөнгөн дүн |
|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 487.2 |
| 80106 | Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 156.5 |
| 80205 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 30.0 |
| 80221 | Гэрээт ажиллагсдын зардал | 210.5 |
| 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 0.9 |
| 82212 | Хур хог хаягдал, орчны бохирдол | 141.7 |
| 81701 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал | 19.0 |

| | | |
|---|---|---|
| 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал | 120.0 |
| 80221 | Гэрээт ажиллагсдын зардал | 120.0 |
| | ДҮН | 1,285.8 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ОНХС-аас 11500.0, Хөшөөт хөгжлийн сангаас 23750.0, аймгийн Засаг даргын захирамжаар 1000.0, Онцгой байдлын газраас 144.0, өмнөх оны татан төвлөрүүлэлтээс 7833.7, газрын дуудлага худалдаагаар 580.0, лавлагааны орлого 444.5, статистикийн хэлтсээс судалгааны ажлын зардалд 3796.6, гамшгаас хамгаалах зардалд 9100.0, 1987 оны төгсөгчид хандив 900.0, тендерийн баримт бичгийн орлого 48.0 мянган төгрөг нийт 59096.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс орон сууц хүн амын тооллого, хагас жилийн мал тооллогын судалгааны зардалд 3787.9 мянга, сургуульд камержуулалт, дотуур байрны тоног төхөөрөмж 19000.0, цэцэрлэгт тоног төхөөрөмж авахад 4536.1, Соёлын төвийн тохижилтод мянга нийт 56722.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 7310.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

## 3.7. **ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 116 мэдээллээс хугацаандаа оруулсан 115 мэдээлэл, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, нэмэлт санхүүжилтийн дансны зарлагын ажил гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

## 3.8. **ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12900.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 12,900.0 | | | 1 | 12,900.0 | - |
| Нийт дүн | 1 | 12,900.0 | - | - | 1 | 12,900.0 | 0 |

## 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 160928.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 107833.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 53094.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

**<u>Залруулсан алдаа</u>**:Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нэмэлт санхүүжилтийн данснаас 2327.8 мянган төгрөгийн татан төвлөрүүлсэн авлагаар бүртгээгүй,
2. Мөнгөн гүйлгээний тайланд 7833.7 мянган төгрөгөөр орлого дутуу тусгасан,
3. Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэргүй ундны ус зөөвөрлөх автомашиныг 50000.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгөд бүртгэсэн,
4. Тайлант оны элэгдлийн зардлыг 10181.6 мянган төгрөгөөр илүү тусгасан,
5. Тайлант үеийн үр дүнг 37490.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэнтэй холбоотой залруулгыг аудитын явцад хийгдлээ.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>***: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 107833.7 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 53094.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Сумын сургууль, цэцэрлэг, соёлын төвд тоног төхөөрөмж хөрөнгө худалдан авахад шууд гэрээ хийхдээ харьцуулалт хийгээгүй, үнийн санал аваагүй, 35036.1 мянган төгрөгөөр аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулан хэрэгжүүлсэн, зах зээлийн үнэ ханшаас өндөр үнээр нийлүүлсэн,
2. Засаг дарга нь шатахуун олгох зөвшөөрлийн бичгийг өөрөө бичиж олгодог, тайлант онд нийт 14180.6 мянган төгрөгийг шатахуунд зарцуулсан ч эд хариуцагч нь тайлан гаргаагүй, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй,
3. Төрийн сангийн мэргэжилтэн хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд Санхүүгийн албаны дарга, Орлогч дарга нарыг хавсран ажиллуулан 1877.9 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон,
4. Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2000.0 мянган төгрөгийг ЗДТГ-ын үйл ажиллагааны зардалд зарцуулсан нь зэрэг зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар ТЕЗ-тай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" , ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно", 33.2-д "Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ", 33.2.1-д "үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5-д " дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хууль 28 дугаар зүйл.Хэд хэдэн ажил олгогчид нэгэн зэрэг ажиллахыг хориглох 28.1-д "Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт

байгуулахыг хориглоно", Төрийн албаны тухай хууль 43 дугаар зүйл."Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам, 43.1-д "Энэ хуулийн 43.3.1-д зааснаас бусад тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан 14 хоногийн дотор гаргана. 43.3.3-д "энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх;", Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна", заалттай нийцээгүй, аудитын "иж бүрэн байх", "тохиолдсон байх", "үнэлгээ" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

## 3.0. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудалгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2021 | Аудитын нэр: | ***Дөргөн сумын Засаг даргын тамгын газрын** 2020 **оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: ХОА-2021/159/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Дөргөн сумын Засаг даргын тамгын газар** | Мянган төгрөгөөр | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Авлага дутуу тусгасан | 2327.8 | Залруулга хийх | Тамгын газрын дарга , нягтлан бодогч | Б.Баттогтох Б.Бадамгарав |
| 2 | Орлого дутуу тусгасан | 7833.7 | Залруулга хийх | | |
| 3 | Тайлант үеийн үр дүн зөрүүтэй илэрхийлсэн | 37490.6 | Залруулга хийх | | |
| 4 | Тайлант оны элэгдлийн зардал зөрүүтэй илэрхийлсэн | 10181.6 | Залруулга хийх | | |
| 5 | 2019 оны УТХО-оор Тэнчи ХХК-ны нийлүүлсэн ундны усны зориулалтаар ашиглах усны машин нийлүүлэхээр заасан боловч уг автомашиныг ундны усны зориулалтаар ашиглах боломжгүй зэв гарч зориулалтын дагуу ашиглагдахгүй аймгийн ИТХ-ын тогтоол | 50000.0 | Залруулга хийх | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шийдвэр гаргаагүй санхүүгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн | | | | |
| 6 | Сумын сургууль, цэцэрлэг, Соёлын төвд тоног төхөөрөмж, камержуулалтыг Хөшөө хөгжлийн сан болон ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэхдээ тендерийн тухай хуулийн заалтуудыг мөрдөөгүй, ил тод мэдээлээгүй, харьцуулалт хийгээгүй, урилга илгээгүй, шууд гэрээ байгуулсан | 35036.1 | Албан шаардлага | Тамгын газрын дарга , нягтлан бодогч | Б.Баттогтох Б.Бадамгарав |
| 7 | Засаг дарга нь шатахуун олгох зөвшөөрлийн бичгийг өөрөө бичиж олгодог, тайлант онд шатахуунд зарцуулсан ч эд хариуцагч нь тайлан гаргаагүй, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, | 14180.6 | Албан шаардлага | Тамгын газрын дарга , нягтлан бодогч | Б.Баттогтох Б.Бадамгарав |
| 8 | Төрийн сангийн мэргэжилтэн хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд Санхүүгийн албаны дарга, Орлогч дарга нар хавсран ажиллуулан нэмэгдэл цалин олгосон, | 1877.9 | Албан шаардлага | Тамгын газрын дарга , нягтлан бодогч | Б.Баттогтох Б.Бадамгарав |
| 9 | Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2000.0 мянган төгрөгийг ЗДТГ-ын үйл ажиллагааны зардалд зарцуулсан | 2000.0 | Албан шаардлага | Тамгын газрын дарга , нягтлан бодогч | Б.Баттогтох Б.Бадамгарав |
| **ДҮН** | | 160928.3 | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**